

ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/15

Мандалговь

“Эрүүл мэндийн газрын нийгмийн баталгааг
хангах” хөтөлбөр батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 24 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн газрын ажиллагсдын ажиллах орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулах, нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн газрын ажиллагсадын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг нэгдүгээр, Эрүүл мэндийн газрын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, хэрэгжүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг УТСХ-ийн дарга /Ц.Энхсайхан/, ХШҮ, дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн /П.Оюунчимэг/ нарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ  Г.БАТ-ОРШИХ



Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн
А/15 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЖИЛЛАГСДЫН
“НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨР**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Үндэслэл:

2017 оны байдлаар аймгийн Эрүүл мэндийн газарт **Нийгмийн эрүүл мэндийн хэлтэст:** Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга, Биеийн тамир, чийрэгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн, Орчны эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн дэмжих сургалт сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн, **Эмнэлгийн тусламжийн хэлтэст:** Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга, Эмийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн, Сувилахуй, ахмад настны асуудал хариуцсан мэргэжилтэн, Анхан шатны тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Гамшиг, яаралтай үеийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, Эмнэлгийн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, **Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтэст:** Удирдлага, төлөвлөлт, санхүүгийн хэлтсийн дарга, Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн, мэдээллийн технологи, зайн оношлогоо хариуцсан мэргэжилтэн, Эмийн хангамж, эмнэлгийн тоног төхөөрөмжийн төлөвлөлт, худалдан авалт хариуцсан мэргэжилтэн, Эрүүл мэндийн статистик мэдээ мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, Эдийн засагч-1, Нягтлан бодогч-1, статистикч бага эмч-1, архив, даргын туслах-бичиг хэргийн ажилтан-1, жолооч-2, үйлчлэгч-1, нярав-1, сахиул-1, цахилгаанчин-1 нийт 26 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнууд ажиллаж байгаагаас 16 буюу 61,5% нь эмэгтэй, 10 буюу 38,5% нь эрэгтэйчүүд бөгөөд 93,3% нь гэрлэсэн, 6.7% нь ганц бие төрийн албан хаагч ажиллаж байна.

Мэргэжлээр нь авч үзвэл хүүхдийн эмч 1, мэс заслын эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмч 1, тархвар судлагч эмч 2, эм зүйч 2, ерөнхий мэргэжлийн эмч 1, статистикч эмч 1, лаборторын эмч 1, эмчилгээний арга зүйч 1, төрийн удирдлагын мэргэжилтэй 1, эдийн засагч 2, нягтлан бодогч 1, Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн 1, статистикч бага эмч 1, мэдээллийн технологийн мэргэжилтэн 1, жолооч 2, архив, бичиг хэргийн мэргэжилтэн ажилтан 1, цахилгаанчин 1 зэрэг болно.

Эрүүл мэндийн газарт төрийн захиргааны албан хаагч 14, төрийн үйлчилгээний албан хаагч 12 хүнээс ахлах түшмэлийн тэргүүн зэрэгтэй 1, ахлах түшмэл дөтгөөр зэрэгтэй 1, дэс түшмэлийн дөтгөөр зэрэгтэй 4, дэс түшмэлийн гутгаар зэрэгтэй 1, Дэд зэрэг дэс түшмэл 1 нийт 8 зэрэг дэвтэй төрийн албан хаагч, Тэргүүлэх зэрэгтэй 2 эмч, Эрүүл мэндийн удирдлагын ахлах зэрэгтэй эмч 1, эрүүл мэндийн статистикч ахлах зэрэгтэй 2 мэргэжилтэн, ахлах зэрэгтэй 1 бага эмч ажиллаж байна.

Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон 1, Алтан гадас одон 1, Хөдөлмөрийн хүндэт мадаль 2, "Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан" цол, тэмдгээр 9, "Хүндэт жуух" бичгээр 13 хүн тус тус шагнагдсан байна.

Аймгийн Эрүүл мэндийн газарт 14 төрийн жинхэнэ албан хаагч ажилладаг ба албан хаагчдын 53,3% нь шинээр зэрэг дэв авсан буюу ахиулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 15-20%-аар олгож байна.

Насны ангилалаар нь авч үзвэл 20-29 насны 4, 30-39 насны 10, 40-49 насны 7, 50-59 насны 4, 60-аас дээш-1 хүн байна.

Нийгмийн баталгааг хангах суурь судалгаанаас үзэхэд эрүүл мэндийн газар ажиллаж буй ажилчдын сарын дундаж орлого 650000-1000000 төгрөг, нэг гэр бүл дунджаар 3-5 ам бүлтэй байгаа ба өрхийн нэг иргэнд 200,000 төгрөг ноогдож байна. Энэ нь өрхийн амжиргааны баталгаажих түвшинг бүсийн хувьд хангаж байгаа мэт боловч бусад бүстэй харьцуулахад хангалтгүй буюу анхаарах асуудал болоод байгаа юм.

Орон байрны хувьд 10 буюу 38,5% нь гэр хороололд 8 буюу 30,7% нь нийтийн зориулалттай орон сууц, 7 буюу 26,9% нь амны хувийн орон сууцтай, 1 буюу 3,9% нь түрээсийн байранд амьдарч байна. Орон сууцны зээлд 5 буюу 19,2% нь хамрагдсан байна.

Эрүүл мэндийн газрын нийт ажилчдын 92,3 нь зээлтэй үүний 84,6% нь цалингийн, 11,5% нь орон сууцны зээл, 19,2 нь бизнесийн болон бусад зээлтэй байна.

Энэхүү өрхийн орлого нь тухайн өрхийн орон байр, сургалтын төлбөр, өдөр тутмын хэрэглээ зэрэг амьдралын баталгааг хангах эдийн засгийн хөшүүрэг болох ёстой боловч эрүүл мэндийн газрын ажиллагсдын цалин хөлс нийгмийн баталгааг хангах санхүүгийн эх үүсвэр болж чадахгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Иймээс эрүүл мэндийн газрын ажиллагсдын ажиллах, амьдрах нөхцөлийг жигд сайжруулж, нийгмийн асуудлыг үнэн зөв бодит судалгаанд үндэслэн

нээлттэй ил тод шийдвэрлэх нь эрүүл мэндийн газрын ажиллагсдыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй, идэвхи санаачилгатай ажиллуулахын тулд энэхүү хөтөлбөрийг боловсруулан гаргах зайлшгүй шаардлага бий болоод байна.

1.2 Хамрах хүрээ:

Энэ хөтөлбөрт аймгийн эрүүл мэндийн газрын нийт ажиллагсад хамрагдана.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1.Зорилго:

Эрүүл мэндийн газрын ажиллагсдын ажиллах орчин нөхцөлийг тасралтгүй сайжруулах, нийгмийн баталгааг хангах замаар ажиллагсдын сэтгэл ханамжтай, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2 Зорилт:

2.2.1 Эрүүл мэндийн газрын ажиллагсдыг эрхэлсэн ажлаа мэргэжлийн түвшинд, чанартай гүйцэтгэх боломжийг бий болгох

2.2.2 Эрүүл мэндийн газрын ажиллагсдын ажиллах нөхцөл, амьдрах орчин, баталгааг хангах үйл ажиллагааны чиглэл, сайжруулах арга замыг тодорхойлох

Гурав. Хөтөлбөрийн хугацаа, санхүүжилт:

3.1. Хугацаа: 2018-2020

3.2 Хөтөлбөрийн санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.2.1 Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө

3.2.2 Төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хандив тусламж

3.2.3 Бусад эх үүсвэр, төсөл хөтөлбөр, сан

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хүрэх үр дүн

4.1. Ажиллагсдыг орон сууцаар хангах, нөхцөлийг сайжруулах

4.1.1 Эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс орон нутгийн удирдлага, байгууллагын дэмжлэгээр орон нутгийн болон байгууллагын төсвөөр орон сууц, хашаа байшин, газар олгох зэргээр тусламж үзүүлэх

4.1.2 Эрүүл мэндийн газарт олон жил тогтвортой, үр бүтээлтэй ажиллаж байгаа амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой ажиллагсдын

судалгааг жил бүр гарган амьдрах орчин нөхцөлийг сайжруулах, орон байр, хашаа байшингаар хангах дэмжлэг авах боломжийг эрэлхийлэх, шийдвэрлэх

4.2. Ажиллах нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр

4.2.1 Ажиллах орчин нөхцөлийг стандартын жишигт нийцүүлэн тохижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх

4.2.2 Ажиллагсдын үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай материаллаг бааз, компьютер, техник хэрэгсэлээр хангах асуудлыг ажилчдаас санал авсны үндсэн дээр жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэх

4.2.3 Ажиллагсдыг улирал бүр хагас бүтэн жилээр ажлыг дүгнэн мөнгөн урамшуулал олгохоос гадна албан тушаал ахиулах, төрийн албан хаагчдыг зэрэг дэв нэмэх, төр засгийн шагналаар шагнах, гадаад дотоодын сургалтанд хамруулах, туршлага судлуулах зэрэг хууль тогтоомжинд нийцүүлэн урамшуулан дэмжих

4.2.4 Шинээр гэр бүл болох, хүүхэд төрүүлэх, шинэ байранд орох, төрийн одон медалиар шагнуулах зэрэгт байгууллагаас эд хөрөнгө болон мөнгөн тусламж үзүүлэхийг дотоод журмын заалтын дагуу шийдвэрлэх

4.2.5 Ар гэрт нь гачигдал гарах, биеийн эрүүл мэндийн байдлаас эмчлүүлэх, сувилуулах, эцэг эхийн насны ой тэмдэглэх, хүүхдийн даахь үргээх, үр хүүхэд төрсөн ах дүү хуримаа хийх, диплом, эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цалинтай чөлөө олгох

4.3. Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр

4.3.1 Ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор байгууллагын эмчийг томилон ажиллуулж, жилд 1-ээс доошгүй удаа анхан шатны эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, шаардлагатай тохиолдолд эмчилгээнд хамруулах

4.3.2 Нийт ажиллагсдад эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх зорилгоор эрүүл мэнд, зөв зохистой хооллолт, сэтгэл зүй, дасгал хөдөлгөөний сургалтанд хамруулж, витаминжуулах, аарц, чацаргана гэх мэт амин дэмтэй хүнсээр хангах ажлыг зохион байгуулах

4.3.3 Ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, ажилчдын дунд урлаг, спортын үйл ажиллагааг зохион байгуулах, долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглуулах, урлаг спортын үйл ажиллагаанд байгууллагын зүгээс

санхүүгийн дэмжлэг үзүүлэх, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг өдөр бүр хэвшүүлэх зэрэг арга хэмжээг тогтмолжуулах

4.4 Ажилчдыг сургаж, мэргэшүүлэх чиглэлээр

4.4.1 Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн хөгжлийн болон сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах

4.4.2 Ажилтнуудын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургалтанд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэх

4.4.3 Мэдлэг боловсролоо дээшлүүлэх зорилгоор өөрийн хөрөнгөөр давтан сурах, мэргэшлээ дээшлүүлэх энэ хугацаанд тэднийг ажлаас нь түр чөлөөлөх, эрхэлж байгаа албан тушаалын цалин хөлсийг олгох зэргээр дэмжлэг үзүүлэх

4.4.4. Шинээр ажилд томилогдсон эмч, эмнэлгийн мэргэжилтэнд тухайн байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, байгууллагын соёл, дотоод журам болон ёс зүйн дүрэм зэрэг шаардлагатай мэдээллээр хангах

4.5 Ажилчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх чиглэлээр

4.5.1 Баяр ёслол, амралтын өдрүүдэд хамт олон гэр бүлээрээ тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

4.5.2 Ээлжийн амралтаараа эмнэлэг, сувилалд хэвтэн эмчлүүлэхэд нь замын зардал болон бусад тусламж олгох нөхцөлийг судлан хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх

4.6 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт

4.6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хагас бүтэн жилээр гаргах

4.6.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар ажилчид санал, хүсэлт, хөтөлбөрт тодотгол нэмэлт өөрчлөлт оруулах

4.6.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийг жилд 1 удаа ЭМГ-ын удирдлагын багт тайлагнах

Эрүүл мэндийн газрын даргын
2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн
А/15 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН "НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ" ХӨТӨЛБӨРИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа			Санхүүжилт	Хариуцах эзэн
		2018	2019	2020		
1	Ажилтнуудад "Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг танилцуулах	+				Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
2	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас бүтэн жилээр гаргах	+	+	+		Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
3	Ажилчдаас санал, хүсэлт авч төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах	+	+	+		Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
Ажиллагсдыг орон сууцаар хангах, нөхцөлийг сайжруулах						
4	Ажилчдаас орон байрны зээл, төрийн албан хаагчийн хөнгөлөлттэй урт хугацааны зээлийг эхний ээлжинд хамруулах	+	+	+		Эрүүл мэндийн газрын дарга /Г.Бат-Орших/
5	Ажилчдын орон сууцны нөхцөлийн судалгааг тогтмол гаргах	+	+	+		Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
Ажиллах нөхцөл боломжийг сайжруулах чиглэлээр						
6	Ажилтнуудын ажлын үр дүнг тооцож урамшуулал олгох, орон нутгийн болоод салбарын, төрийн дээд шагналд тодорхойлох	+	+	+	Улсын төсөв	Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
7	Ажлын байрны тав тухтай орчин бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм, зааврыг хангаж эмнэлэг бүр "Эрүүл мэндийг дэмжигч байгууллага" болох хөдөлгөөнийг өрнүүлж ажиллах	+				НЭМХ

8	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус албаны үйл ажиллагааг тогтмолжуулах	+			+		Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
9	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалт зохион байгуулах	+	+		+		Биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн /Ц.Загдсүрэн/
10	Орон сууцны болон цалингийн зээл хөнгөлөлттэй олгуулах боломжийг судалж, шийдвэрлэх	+	+		+		Эрүүл мэндийн газрын дарга /Г.Бат-Орших/
11	Ажилтнуудад баярт үйл явдал болон гачигдал тохиолдох үед байгууллагын дотоод журмын дагуу урамшуулал, буцалтгүй тусламж олгож байх	+	+		+	Дундын фонд	Нягтлан бодогч /Ч.Бямба/
12	Жил бүр байгууллагын "Аварга ажилтан" шалгаруулж, самбарт зургыг нь тавьж алдаршуулах	+	+		+	Байгууллагын зардал	Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
13	Албан хаагчдийн өрхийн орлогыг зохих хэмжээгээр нэмэгдүүлэхийн тулд туслах аж ахуй эрхлэх, ногоо тарихад нь дэмжлэг үзүүлж зохион байгуулалтын арга хэмжээ авч байх	+	+		+		Нягтлан бодогч /Ч.Бямба/
14	Цалин хөлс, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар хийгдэж байгаа төсөл хөтөлбөрийн мэдээллийн сан, судалгааг бүрдүүлэх	+	+		+		Б.Буяннэмэх /Эдийн засагч
Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр							
15	Байгууллагын ажилтнуудын эрүүл мэндийг хариуцсан эмч томилох	+	+		+	-	ХШҮ-ийн мэргэжилтэн /П.Оюунчимэг/
16	Ажилчдыг жилд 1-ээс доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	+	+		+	-	ЭТХ-ийн мэргэжилтэн /Г.Улааннаран/
17	Эрүүлжүүлэх арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах	+	+		+	Байгууллагын зардал	ЭТХ-ийн мэргэжилтэн /Г.Улааннаран/
Ажилчдыг сургаж, мэргэшүүлэх чиглэлээр							
18	Ажилтануудыг гадаадад сургалтанд хамруулах, туршлага судлах танилцах, аялалд явуулах	+	+		+	Хандив тусламж, дэмжлэг	Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/

19	Ажилтнуудыг богино хугацааны сургалтуудад тогтмол хамруулж, багц цагаа биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх	+	+	+	+	Хувь хүний зардал	Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
20	Ажилтнуудыг төгсөлтийн дараах сургалтанд ахмуулах	+	+	+	+	Төрийн сангийн зардлаар	Хүний нөөцийн мэргэжилтэн /Р.Мөнхбаясгалан/
21	Ажилтнуудыг хууль эрх зүй, ёс зүйн сургалтан дхамруулах	+	+	+	+	Байгууллагын зардал	ХШУ-ийн мэргэжилтэн /П.Оюунчимэг/
Ажилчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрөөх чиглэлээр							
20	Рашаан сувилалд хөнгөлөлттэй хамруулах, хамруулах ажлыг зохион байгуулах	+	+	+	+	-	ХШУ-ийн мэргэжилтэн /П.Оюунчимэг/
21	Ажигчдыг байгалийн үзэсгэлэнт газруудаар тойрон аялалаар явуулах, тэдний хооронд ажил мэргэшлийн аварга шалгаруулах уралдаан, урлаг спортын тэмцээн тогтмол зохиож байх	+	+	+	+	Хувь хүний зардал	Биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн /Ц.Загдсүрэн/
22	Ажилтнуудыг жил тутам эрүүл мэндийн сорилд хамруулж, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх арга хэмжээ авах	+	+	+	+	-	Биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн /Ц.Загдсүрэн/